# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 18 өдөр　　　　Дугаар 87　　　　Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2026 оны 03 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар 2026-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс болон орон нутгийн төсөвтөө тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД　　　　Г.ЗАНДАНШАТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД　　　　Ж.ЧИНБҮРЭН

Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 87 дугаар тогтоолын хавсралт

# МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР 2026-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Санхүүжилтийн эх үүсвэр | Хүрэх түвшин | Хэрэгжих хугацаа (он, улирал) | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг.Уламжлалт анагаахын салбарын бүтэц, зохион байгуулалт, тусламж үйлчилгээ, санхүүжилт, дэд бүтцийн хөгжлийг дэмжсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр | | | | | | | | | |
| 1.1 | Уламжлалт анагаах ухааны анхдагч хуулийн төслийг боловсруулах | Хуулийн төсөл боловсруулах | - | - | Улсын төсөв | Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна | 2026-2027он | Эрүүл мэндийн яам | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| 1.2 | Уламжлалт анагаах ухааны эмнэлзүй, сургалт, судалгааг хөгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний төв байгуулах, түүнтэй уялдсан эмийн үйлдвэрлэл, инновацын кластер хөгжүүлэх боломжийг судлах | Уламжлалт анагаах ухааны үндэсний төв | Явцын хувь | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны үндэсний төвийг байгуулсан байна | 2026-2027он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам<br>Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох | Эрүүл мэндийн даатгалын үндсэний зөвлөлийн тогтоол | - | ЭМДҮЗ-03,04 тогтоол, ЭМС-ын 2022 оны А/55 дугаар тушаал | - | Эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна | 2026 он III улирал | Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| 1.4 | Уламжлалт эмийн түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, худалдаалах үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх | Шийдвэрийн тоо | - | - | - | Уламжлалт эмийн түүхий эдийн ашиглалт, нийлүүлэлт хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна | 2026-2027он | Эрүүл мэндийн яам | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |
| 1.5 | Уламжлалт эмийн түүхий эд болон бэлдмэлийн чанар, найрлага, шинжилгээний аргачлалыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоож, фармакопейн өгүүллийг баталж мөрдүүлэх | Фармакопейн өгүүлэл | - | - | - | Фармакопейн өгүүллийг баталж, мөрдүүлсэн байна | 2027 он II улирал | Эрүүл мэндийн яам | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |
| 1.6 | Уламжлалт анагаах ухааны эмийн салбарт ажиллах эмч | Тушаал шийдвэр | - | - | - | Уламжлалт анагаах ухааны эмийн салбарын | 2026 он IV улирал | Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийн хөгжлийн төв |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжилтнийг бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | | хүний нөөц нэмэгдсэн байна | | | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль |
| 1.7 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд уламжлалт анагаах ухааны ухааны тусламж, үйлчилгээг үзүүлэх бие даасан бүтцийг бий болгох | Шийдвэрийн тоо | - | - | - | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг үзүүлэх бие даасан бүтэц, зохион байгуулалтыг хийсэн байна | 2026 он III улирал | Эрүүл мэндийн яам | Бүх шатны эрүүл мэндийн байгууллага Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар Эрүүл мэндийн хөгжлийн төв Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| Хоёр.Уламжлалт анагаахын эх сурвалж, өвийг судлан шинжлэх, уламжлалт болон орчин цагийн анагаах ухааны нийцлийг тогтоож, дэвшилтэт технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагааг дэмжиж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, оюуны өмчийн эрхийг баталгаажуулах арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Уламжлалт анагаах ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, уламжлалт анагаах ухаан болон орчин үеийн анагаах ухааны нийцлийг тогтоох | Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний үр дүнг орчин цагийн анагаах ухааны багажийн шинжилгээгээр шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нотолсон эсэх | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн батлуулсан байна | 2027-2030 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам<br>Боловсролын яам<br>Шинжлэх ухааны академи |
| 2.2 | Хиймэл оюунд суурилсан уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний технологийг судалж, туршилт нэвтрүүлэлтийг хийх | Нэвтрүүлсэн шинэ технологийн тоо | - | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн байна | 2026-2028 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам<br>Боловсролын яам<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам<br>Математик тоон технологийн хүрээлэн |
| 2.3 | Уламжлалт анагаах ухааны их өгөгдлийн сан бүрдүүлэх | Их өгөгдлийн сан | 1 | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны их өгөгдлийн нэгдсэн сан үүссэн байна | 2027-2030 он | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам | Эрүүл мэндийн яам<br>Үндэсний дата төв<br>Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 2.4 | Соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрт Уламжлалт анагаах | Батлагдсан хөтөлбөр | Хэрэгжилтийн хувь | Соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр | Улсын төсөв | Соёлын өвийн үндэсний хөтөлбөрт тусгагдсан байна | 2027-2028 он | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | Эрүүл мэндийн яам<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ухааныг тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | | | | | |
| 2.5 | Уламжлалт анагаах ухааны эх сурвалж, биет болон биет бус өвийг хамгаалах, цахимжуулах, судалгааны эргэлтэд оруулах | Судалгааны тайлан | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны соёлын биет болон биет бус өвийг бүртгэж цахимжуулах, судалгааны эргэлтэд оруулсан байна | 2027-2028 он | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам | Эрүүл мэндийн яам Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 2.6 | Уламжлалт анагаах ухааны инновацын хөгжил, оюуны өмчийн баталгаажилтыг эрчимжүүлэх | Оюуны өмчийн баталгаажилтын тоо | Тоо | - | Улсын төсөв | Инновацын бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, оюуны өмчийн нэгдсэн санг үүсгэсэн байна | 2027-2029 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Оюуны өмчийн газар |
| 2.7 | Уламжлалт анагаах ухаанд суурилсан Биотехнологийн парк байгуулах эрхзүйн орчныг бүрдүүлэх | Биотехнологийн парк шинээр байгуулах | Тоо | 1 | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухаанд суурилсан Биотехнологийн парк байгуулсан байна | 2027-2030 он | Эрүүл мэндийн яам | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Эдийн засаг, хөгжлийн яам Боловсролын яам |
| Гурав.Уламжлалт анагаах ухааны эмч, мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалт, сургалт, судалгааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулах, сургалтын хөтөлбөрийг олон улсын стандартад нийцүүлэх, салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиглэлээр | | | | | | | | | |
| 3.1 | Уламжлалт анагаах ухааны сургалттай ерөнхий | Засгийн газрын тогтоол | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Ерөнхий боловсролын сургууль | 2026 он II улирал | Боловсролын яам | Сангийн яам Эрүүл мэндийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролын сургууль байгуулах | | | | | байгуулсан байна | | | |
| 3.2 | Уламжлалт анагаахын их эмч бэлтгэх цөм хөтөлбөр боловсруулж, чанарын баталгаажилтыг хангах | Уламжлалт анагаахын их эмчийн цөм хөтөлбөр | Тоо | 1 | Улсын төсөв | Сургалтын хөтөлбөр боловсруулан дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлсэн байна | 2027-2028 он | Боловсролын яам | Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл |
| 3.3 | Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийг дээд боловсролын удирдлага мэдээллийн санд бүртгэх | Бүртгэлийн тоо | - | - | Улсын төсөв | Хүний нөөцийг нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн байна | 2026-2028 он | Боловсролын яам | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 3.4 | Уламжлалт анагаах ухааны эмч нарын чадавхыг дээшлүүлэх зорилгоор жил бүр бодлогын тэтгэлэг зарлах | Уламжлалт анагаах ухааны 50 эмч тэтгэлэгт хамруулах | - | - | Олон улсын төсөл, хөтөлбөр | Уламжлалт анагаахын эмчийг гадаад тэтгэлэгт хамруулж, чадавхжуулсан байна | Жил бүр | Боловсролын яам | Сангийн яам Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн хөгжлийн төв |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Уламжлалт анагаах ухааны туслах сувилагч, бариа засалч, эмийн технологийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх | 30 хувиар нэмэгдүүлэх | Хувь | - | Улсын төсөв | Төгсөгчдийн тоог нэмэгдүүлсэн байна | 2030 он I улирал | Эрүүл мэндийн яам | Боловсролын яам Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 3.6 | Төгсөлтийн дараах Уламжлалт анагаах ухааны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг чанарын шинэ түвшинд хүргэх | Шинэчлэгдсэн хөтөлбөр | 1 | - | Улсын төсөв | Төгсөлтийн дараах хөтөлбөрийг шинэчилсэн байна | 2028 он II улирал | Эрүүл мэндийн яам | Боловсролын яам Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 3.7 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад Уламжлалт анагаах ухааны эмч, сувилагчийн хүртээмжийг нэмэгдүүлэх | Шийдвэрийн тоо | - | - | - | Хүртээмжийг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна | 2026-2027 он | Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| 3.8 | Уламжлалт анагаах ухааны их эмчийг үндсэн мэргэшил эзэмшүүлэхэд шаардлага хангасан багц цагийн зөрүү | Сургалтын хөтөлбөр | - | - | - | Шаардлага хангасан чиглэлд багц цагийн зөрүүг гаргасан байна | 2026 он IV улирал | Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийн хөгжлийн төв Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргасан чиглэлд мэргэшүүлэх боломжийг судлах | | | | | | | | |
| Дөрөв.Уламжлалт эмийн түүхий эдийн тархац, нөөц, эмийн найрлага, технологи, үйлдлийг судлах, ховор эмийн ургамлыг хамгаалах, тарималжуулах, уламжлалт эм үйлдвэрлэлийн зохистой дадлын стандарт бүхий үйлдвэр, эмийн чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулж, уламжлалт эм ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэн экспортын боломжийг нэмэгдүүлэх, ард иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр | | | | | | | | | |
| 4.1 | Уламжлалт эмийн түүхий эдийн тархац нөөц, тарималжуулалт-ыг нэмэгдүүлэх, эмт амьтныг өсгөж үржүүлэх ажлыг зохион байгуулах | Нөөц тогтоосон түүхий эдийн хэмжээ<br><br>Тарималжуулсан ургамлын тоо<br><br>Өсгөж үржүүлсэн эмт амьтны тоо, толгой | - | - | Улсын төсөв | Уламжлалт эмийн түүхий эдийн тархац нөөц, тарималжуулалт нэмэгдсэн байна | 2026-2028 он | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам<br>Эрүүл мэндийн яам<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br>Шинжлэх ухааны академи |
| 4.2 | Уламжлалт эмийн үйлдвэрүүдэд Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) стандарт нэвтрүүлэх | GMP стандарт нэвтрүүлсэн уламжлалт эмийн үйлдвэрийн тоо | - | GMP шаард-лага хангасан 2 үйлдвэр | Улсын төсөв | Уламжлалт эмийн үйлдвэрүүдэд GMP стандартыг үе шаттайгаар нэвтрүүлсэн байна | 2026-2028 он | Эдийн засаг, хөгжлийн яам | Сангийн яам<br>Эрүүл мэндийн яам<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |
| 4.3 | Уламжлалт эмийн үйлдвэрлэлийн технологи, чанар, аюулгүй байдлын лаборатори байгуулах | Лаборатори байгуулах ажлын явц | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт эм, эмийн түүхий эдийн чанарын баталгаажилт хийх лаборатори байгуулагдсан байна | 2027-2029 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам<br>Сангийн яам<br>Эрүүл мэндийн хөгжлийн төв<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | зохицуулалтын газар |
| 4.4 | Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) шаардлага хангасан Уламжлалт эмийн улсын нэгдсэн үйлдвэр байгуулах | Гүйцэтгэлийн хувь | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг олон улсын чанарын түвшинд хүргэсэн байна | 2026-2029 он | Эдийн засаг, хөгжлийн яам | Сангийн яам Эрүүл мэндийн яам |
| 4.5 | Үндэсний брэнд бүхий уламжлалт эмийг гадаад зах зээлд гаргах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | 10 нэр төрлийн уламжлалт эм | Тоо | - | Улсын төсөв | Уламжлалт эмийг гадаад зах зээлд гаргасан байна | 2027-2029 он | Эрүүл мэндийн яам | Сангийн яам Хууль зүй, дотоод хэргийн яам Гаалийн ерөнхий газар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим |
| 4.6 | Технологийн шинэчлэл бүхий уламжлалт эмийн хэрэглээг нэмэгдүүлэх | Технологийн шинэчлэл бүхий уламжлалт эмийн тоо | Тоо | - | Улсын төсөв | Орчин үеийн хэрэглээнд нийцсэн уламжлалт эмийн хэрэглээ нэмэгдсэн байна | 2027-2028 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яам Эрүүл мэндийн хөгжлийн төв Эм, эмнэлгийн хэрэгслийн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хяналт, зохицуулалтын газар |
| 4.7 | Уламжлалт эм, түүхий эдийн ханган нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх | Эмийн үйлдвэрүүдийн уламжлалт эм, түүхий эдийн ханган нийлүүлэлтийн хувь | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт эмийн хэрэглээ, хүртээмжийг нэмэгдүүлэн, эмийн цахим дэлгүүрт уламжлалт эмийг байршуулж, төсвийн худалдан авалтад уламжлалт эмийн тоо хэмжээг нэмэгдүүлсэн байна | 2027-2028 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам Сангийн яам Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |
| Тав.Уламжлалт анагаах ухааны мэдлэгт тулгуурласан эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн боловсролын хөтөлбөрийг олон нийтэд түгээж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх чиглэлээр | | | | | | | | | |
| 5.1 | Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрт монгол хүний зохистой идээ ундаа, явдал мөр, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх агуулгыг тусгах | Сургалтын хөтөлбөр боловсруулах | - | - | Улсын төсөв | Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт тусгагдсан байна | 2026-2027 он | Боловсролын яам | Сангийн яам Эрүүл мэндийн яам Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз МОНЦАМЭ Агентлаг |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | Уламжлалт анагаах ухааны мэдлэгт суурилсан “Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх | Батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүнд бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн байна | 2027-2028 он | Эрүүл мэндийн яам | Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз МОНЦАМЭ Агентлаг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 5.3 | Уламжлалт анагаах ухаанд суурилсан бясалгал, сэтгэл засал, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний нэгж байгуулах боломжийг судлах | Судалгааны тайлан, төв байгуулах ажлын хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт бясалгал, сэтгэл заслын нэгжийг судлаж, байгуулсан байна | 2027-2029 он | Эрүүл мэндийн яам | Сангийн яам Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 5.4 | Уламжлалт анагаах ухааны тэмдэглэлт өдрийг сурталчлан таниулах | Арга хэмжээний тайлангийн дүн | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны тэмдэглэлт өдрийг олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн байна | Жил бүр | Эрүүл мэндийн яам | Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз МОНЦАМЭ Агентлаг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| Зургаа.Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үр дүнг үнэлэх, хяналт-шинжилгээний бүтэц тогтолцоог бий болгох, судалгаа хөгжүүлэлт, эмнэлзүй, технологийн солилцооны чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр | | | | | | | | | |
| 6.1 | Уламжлалт анагаах ухааны тухай хууль, бодлого, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр үнэлэх, дүгнэх | Хэрэгжилтийн тайлангийн дүн | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт хийгдсэн байна | Жил бүр | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | Эрүүл мэндийн яам Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 6.2 | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтын ажиллагаа бүхий уламжлалт анагаах ухааны төв байгуулах асуудлыг судлах | Судалгааны тайлангийн дүн | Хэрэгжилтийн хувь | - | Олон улсын төсөл, хөтөлбөр | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталсан 2025-2034 оны Уламжлалт анагаах ухааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна | 2026-2028 он | Эрүүл мэндийн яам | Гадаад харилцааны яам Боловсролын яам Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| 6.3 | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт- | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь | - | Улсын төсөв | Хяналт-шинжилгээний бүтцийг бий болгосон байна | 2026-2030 он | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар | Эрүүл мэндийн яам Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээний бүтцийг бий болгох | | | | | | | | |
| 6.4 | Судалгаа хөгжүүлэлт, эмнэлзүй, технологийн солилцооны чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад улс орнуудын сайн жишгийг судлах | Төслийн тайлангийн дүн | - | - | Улсын төсөв | Уламжлалт анагаах ухааны эмнэлзүй технологийн чиглэлээр судалгаа хийж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна | 2026-2029 он | Эрүүл мэндийн яам | Эдийн засаг, хөгжлийн яам Гадаад харилцааны яам Шинжлэх ухааны академи |

---o0o---